



**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2021 оны 03 сарын 03 өдөр

Дугаар А/37

Өвт

**Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын  
зэргийн II түвшинд шилжсэнтэй холбогдуулан  
авах арга хэмжээний тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2, 11 дүгээр зүйлийн 11.3.2, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн "Түр журам, заавар батлах тухай" 20 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2020 оны "Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийн II түвшинд шилжүүлсэнтэй холбогдон авах арга хэмжээний тухай" А/100 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улаанбаатар хот, эрсдэлтэй бүс нутгаас ирсэн иргэдийг гэр бүлийн гишүүдийн хамт 7 хоногийн хугацаанд гэрийн ажиглалтад, халдвар хамгааллын дэглэмийг сахиулж, хяналт тавьж ажиллахыг сумын Онцгой комисс (Засаг даргын Тамгын газрын дарга Н.Бат-Эрдэнэ), Цагдаагийн тасаг (Цагдаагийн ахмад Д.Энх-Амгалан), Эрүүл мэндийн төв (О.Отгонболд), Багийн Засаг дарга (Т.Жамъянжав, Д.Даваацэрэн, С.Төмөр, Г.Пүрэвтогтох, Л.Балжинням) нарт тус тус үүрэг болгосугай.
2. Аж ахуйн нэгж, төрийн байгууллагуудаар орж үйлчлүүлж байгаа иргэдийн бүртгэл хийж, хяналт тавьж ажиллахыг байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт үүрэг болгосугай.
3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Засаг даргын орлогч (Л.Батчулуун)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН

